“Гайхамшигт баясгалангийн хурмын сан” бүтээлийн зарим жор, эмийн түүхий эдийг тодруулах судалгаа

Э.Цэнгүүнбилэг[1], Б.Болдсайхан[1], Ж.Байгалмаа[1]

[1]АШУҮИС, МАУОУС
Цахим хаяг: Tsenguun1009@gmail.com, Утас: 99316669

Түлхүүр үг:
Ар үр
Сүгмэл
Гүргүм
Давтамж

Товч утга: Монгол эрдэмтэд Энэтхэг, Төвдийн анагаах ухааны ихэнх зохиол бүтээлүүдийг орчуулан шинжилж судлахын зэрэгцээ өөрийн орны ард түмний өвөрмөц ахуй амьдралын онцлогт тохирсон уламжлалт анагаах ухааны дөрвөн ерөндөг болох идээ ундаа, явдал мөр, эмийн болон бариа засал, төөнөх, самнах, шивэх, дэвтээлэг,ороолт, туулга, ханах, хатгах, гэх мэт заслын эмчилгээний олон аргыг багтаасан чухал бүтээлүүдийг Төвд хэлээр туурвиж барласан байдаг. Иймд 1922 онд цөөн хувиар барлагдсан Бурхан урлагч аяга тахимал Чойжамцын найруулсан “Онцар гадон дэр зод буюу Гайхамшигт баясгалангийн хуримын сан” гэдэг 206 хуудастай 360 орчим эмийн жор найрлагыг багтаасан өмнөх үеийн олон ном зохиолыг шүүн үзэж хэрэгтэй ашигтайг нягт хураангуйлан бичсэнээрээ тухайн үедээ эмч нарын гол чухал гарын авлага болж байжээ.[2] Тус бүтээл дэх таван цул, зургаан сав эрхтэний эмгэгт хэрэглэгддэг жор, тэдгээрт агуулагддаг эмийн түүхий эдүүдийн тоо болон давтамж, эмийн түүхий эдийн ангилалыг эх бичиг сурвалж судлалын арга болох магдлан жагсаах арга, анализ синтезийн арга, герменевтикийн аргуудыг ашиглан тодорхойллоо. Үүний үр дүн “Гайхамшигт баясгалангийн хурмын сан” бүтээл дэх таван цул, зургаан сав эрхтэний эмгэгт хэрэглэгддэг нийт 252 жор найрлага байсан ба эмийн түүхий эдийг дэлгэрэнгүй бичсэн 102 жор байлаа. Тэдгээрт агуулагддаг эмийн түүхий эдүүдийг түүвэрлэхэд нийт 243 байсан. Түүвэрлэсэн эмийн түүхий эдүүдийг гарал үүслээр нь ангилахад ургамлын гаралтай нь 193, амьтаны гаралтай нь 21, эрдэсийн гаралтай нь 29 түүхий эд байлаа. Мөн 243 эмийн түүхий эдийн давтамжийг тодорхойлоход “Арүр”-30, “Сүгмэл”-29, “Гүргүм”-25 удаа давтагдсан байгаа бол давтагдаагүй 97 эмийн түүхий эд байгааг бид энэ удаагийн судалгаагаар тодрууллаа.

Үндэслэл: Дорно дахины анагаах ухаанд монгол мэргэдийн оруулсан оюуны үнэт өвийн судар, зохиолууд олдоод байгаа төдийгүй тэдгээрийг тодруулан судлах, түгээн дэлгэрүүлэх, уламжлал шинэчлэлийн энэхүү эрин үед орчин цагийн анагаах ухааны онолын сэтгэлгээ, эмнэл зүйг хөгжүүлэхэд анагаах ухааны эх сурвалж бүтээлийг нягтлан шинжлэх явдал зайлшгүй тулгараад байна. “Монгол эм найрлага нь өвчнийг анагаах дөрвөн ерөндгийн нэг болох бөгөөд эмийн найрлага болон эмт бодисуудын үйлдлийг мэдэхгүй эмчийг үлгэрлэвээс: Гартаа барьсан зэвсэггүй байлдагч тулалдаанд орж бүрэн зэвсэглэсэн дайсандаа ялагдахтай адил юм”[1] гэж дурьдсан байдаг учир дотор өвчний эмгэгийн үед хэрэглэгддэг жор найрлагыг судлан эмийн төрөл зүйлийг олшруулж практик хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Иймд 1922 онд цөөн хувиар барлагдсан Бурхан урлагч аяга тахимал Чойжамцын найруулсан “Онцар гадон дэр зод буюу Гайхамшигт баясгалангийн хуримын сан” гэдэг 206 хуудастай 360 орчим эмийн жор найрлагыг багтаасан өмнөх үеийн олон ном зохиолыг шүүн үзэж хэрэгтэй ашигтайг нягт хураангуйлан бичсэнээрээ тухайн үедээ эмч нарын гол чухал гарын авлага болж байжээ.[2] Энэхүү сударт судас барих ерөнхий зарчим, өвчний шинж тэмдгийн ялгал, оношлох арга, чихний судлаар оношлох, эмийг номхотгох, эмийн чанарыг товч тодорхой өгүүлснээс гадна нилээд олон жорыг эмх цэгцтэй хавсрагасан байна.[3] Мөн гэмтэл бэртэлд үзүүлэх, ялангуяа цул

эрхтэн доргиж болохыг тэмдэглээд тэдгээрт үзүүлэх тусламжийг дурдсан учир энэхүү бүтээлийг сонгон авч бүтээл дэх таван цул, зургаан сав эрхтэний эмгэгт хэрэглэгддэг жор найрлага болон эмийн түүхий эдүүдийг тодруулан судалгааны эргэлтэнд оруулах зорилго дэвшүүлэн судалгааг хийлээ.

Зорилго: “Гайхамшигт баясгалангийн хурмын сан” бүтээлийн таван цул, зургаан сав эрхтэний эмгэгт хэрэглэгддэг жор, тэдгээрт агуулагддаг эмийн түүхий эдүүдийг тодруулах.

Зорилт:

1. “Гайхамшигт баясгалангийн хурмын сан” бүтээл дэх таван цул, зургаан сав эрхтэний эмгэгт хэрэглэгддэг жор, тэдгээрт агуулагддаг түүхий эдүүдийг түүвэрлэн тоог гаргах.
2. Түүвэрлэсэн түүхий эдүүдийн давтамжийг гаргаж, гарал үүслээр нь ангилах.

Арга аргачлал: Судалгааны ажлыг АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн Уламжлалт жор судлалын тэнхимийг түшиглэн явууллаа. Судалгааг Эх бичиг сурвалж судлалын арга болох Магадлан жагсаах арга, Анализ синтезийн арга, Герменевтикийн аргуудыг ашиглан эх хэрэглэгдэхүүн болох Чойжамцын “Гайхамшигт баясгалангийн хурмын сан” буюу “Онцар гадон дэр зод” төвд эх болон Б.Балгансүрэнийн (1990) орчуулга хэвлэл, З.Санждоржын (1991) орчуулгын хэвлэлийг сонгон авч хэрэглэсэн.

Үр дүн: “Гайхамшигт баясгалангийн хурмын сан” бүтээл дэх таван цул, зургаан сав эрхтэний эмгэгт хэрэглэгддэг нийт 252 жор найрлага байна. Эдгээрээс жор найрлагын нэрээр дурьдсан 150 жор байлаа. Харин эмийн түүхий эдийг дэлгэрэнгүй бичсэн жор найрлага нь 102 жор байлаа. Тэдгээрт агуулагддаг түүхий эдүүдийн түүвэрийн нийт тоо 243 байна. Уламжлалт анагаах ухаанд эмийн түүхий эдийн гарал үүслээр нь амьтаны гаралтай, эрдсийн гаралтай, ургамлын гаралтай түүхий эд гэж ангилдаг. Энэхүү ангиллын дагуу түүвэрлэсэн 243 эмийн түүхий эдүүдийг гарал үүслээр нь ангилахад амьтаны гаралтай нь 21, эрдэсийн гаралтай нь 29, ургамлын гаралтай нь 193 түүхий эд байлаа. Энэхүү бүтээл дэхь дэлгэрэнгүй бичигдсэн 102 жор найрлаганд агуулагдаж буй нийт 243 эмийн түүхий эдийн давтамжийг тодорхойлоход “Арүр”-30, “Сүгмэл”-29, “Гүргүм”-25 удаа давтагдсан байгаа бол давтагдаагүй 97 эмийн түүхий эд байгааг тодрууллаа.

Хэлцэмж: Эх хэрэглэгдэхүүнүүдийг харьцуулан судлахад таван цул, зургаан сав эрхтэний эмгэгт хэрэглэгддэг жор, эмийн түүхий эдийн түүвэрлэсэн тоо нийлсэн буюу нийт 252 жор байгаа нь тохирсон юм.[3] Түүнээс дэлгэрэнгүй найрлагатай 102 жор байсан ба тэдгээрийн дотор нийт 243 эмийн түүхий эд байгааг тодрууллаа. Мөн Б.Балгансүрэнгийн орчуулга болон З.Санждоржийн орчуулгын бүтээлүүдийн нэршлийн болон бичиглэлийн хувьд ялгаатай байгаа жордыг тодруулсан. Үүнд нэр адил найрлага зөрүүтэй бичигдсэн 12 жор байсан. Нэр ялгаатай найрлага адил бичигдсэн 4 жор байна. Нэр болон найрлага зөрүүтэй бичигдсэн 1 жор байсан бол зөвхөн нэг орчуулагад байгаа жор тус бүр нэг байлаа. Мөн жорын давтамжийг тодорхойлоход Гоюу-8 хоёр удаа орсон байсан бол Барагшун-9 жор нэрийн хувьд 2 удаа орсон боловч найрлагын хувьд ялгаатай халуун, хүйтэн өвчний үед хэрэглэдэг 2 өөр найрлагатай жорууд байлаа.[4-6]

Дүгнэлт:

1. “Гайхамшигт баясгалангийн хуримын сан” бүтээлд таван цул, зургаан сав эрхтний эмгэгт хэрэглэгддэг 252 жор байлаа. Дэлгэрэнгүй бичигдсэн 102 жор найрлаганд нийт 243 эмийн түүхий эд байгааг олж тогтоолоо.
2. Эмийн түүхий эдүүдийн давтамжийг тодорхойлоход “Арүр” 30, “Сүгмэл” 29, “Гүргүм” 25 удаа тус тус давтагдаж байсан. Эмийн түүхий эдүүдийг гарал үүслээр нь ангилахад ургамлын гаралтай 193, амьтны гаралтай 21, эрдэсийн гаралтай 29 түүхий эд байгаа нь тодорхойлогдлоо.

Ном зүй:

1. *С.Олдох, Б.Цэрэнцоо, П.Батхуяг. Монгол эмийн судлал. Улаанбаатар. 2013 он. Хуудас 6.*
2. *Ч.Баавгай, Б.Болдсайхан. Монголын уламжлалт анагаах ухаан. 1990 он. Хуудас 36.*
3. *Цахир гэвш, аяга тахималч, гилэн Чойжамцын ཞྭ་མཛོད་དཔའ་སྡེའི་གདེར་ཟབ་བྱང་། 1922 онд барлагдсан.*
4. *З.Санждоржийн орчуулан хэвлүүлсэн Чойжамцын “Онцар гадон дэр зод”. Эрдэнэт хот. 1991 он. Хуудас 54-66, 111-123.*
5. *Б.Балгансүрэнгийн орчууан хэвлүүлсэн Чойжамцын “Онцар гадон дэр зод”. УБ. 1990 он. Хуудас 64-81, 139-162.*
6. *Анагаах ухааны дөрвөн үндэс (Хөрвүүлсэн Х.Тумбаа) УБ.1991. Хуудас 331-353*

The results of a study to clarify some recipes and medicinal raw materials of the "Wonderful joy wedding foundation"

Tsenguunbileg E[1], Boldsaikhan B[2], Baigalmaa J[1]

[1]ISMM, MNUMS
Email: Tsenguun1009@gmail.com, Tel: 99316669

Mongolian scholars have translated and studied many Indian and Tibetan medical texts, as well as traditional treatments such as food, medicine, medicine and bariatric surgery, burns, combs, saturation, stitches, and soaks, which are adapted to the specific life of the people of their country. Important works, including many methods, have been written in Tibetan. Therefore, it is important to note that in 1922, Choijamts, a small-scale Buddhist sculptor, wrote a summary of many of the previous books, including a 206-page, 360-page recipe called "Ontsar Gadon Der Zod or the Wedding Fund of Wonderful Joy." The recipes used in the five-volume and six-vessel diseases, the number and frequency of drug raw materials contained in them, and the classification of drug raw materials are determined using source methods such as identification, analysis, synthesis, and hermeneutics. . As a result, there are a total of 252 recipes used in the treatment of five monolithic and six vascular diseases in the book "Wonderful Joy Wedding Foundation" and 102 recipes detailing the medicinal raw materials. The total number of samples of medicinal raw materials contained in them was 243. The sampled medicinal raw materials were classified according to their origin into 193 raw materials of plant origin, 21 raw materials of animal origin, and 29 raw materials of mineral origin. In order to determine the frequency of 243 drug raw materials, we found that "Arur" -30, "Sugmel" -29, and "Gurgum" -25 were repeated, while 97 raw materials were not repeated.

Key words: Arur, sugmel, gurgum, frequency